



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2023 оны 09 дүгээр сарын 11
№34 (1282)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

490.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2679
491.	Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай	2728

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

492.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 42	2729
493.	Засгийн газарт чиглэл өгөх тухай	Дугаар 47	2730

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

494.	Журам шинэчлэн батлах тухай	Дугаар 60	2732
495.	Үндэсний энгийн гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам шинэчлэн батлах тухай	Дугаар 71	2739
496.	Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сангийн дүрэм, журам батлах тухай	Дугаар 72	2748

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 06 дугаар
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг:

“5.2. Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яам, Олон улсын байгууллагын дэргэд суугаа Монгол Улсын Байнгын Төлөөлөгчийн газар, Монгол Улсын Ерөнхий консулын газар, Консулын газар, Консулын төлөөлөгчийн газар /цаашид “Дипломат төлөөлөгчийн газар” гэх/ байрладаг гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэн сонгуульд оролцож, санал өгөх эрхтэй.”

2/9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг:

“9.3. Гадаад улсад байгаа иргэдээс санал авах өдөр /цаашид “гадаадад санал авах өдөр” гэх/-ийг сонгуулийн төв байгууллага /цаашид “Сонгуулийн ерөнхий хороо” гэх/-ын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтоох бөгөөд гадаадад санал авах өдөр нь дөрөв хүртэл өдөр байна.”

3/10 дугаар зүйлийн 10.1.14 дэх заалт:

“10.1.14. гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажиллагааг зохион байгуулахтай холбогдон гарах зардал;”

4/11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг:

“11.4. Улсын Их Хурлын гишүүнийг энэ хуулийн 4.3.2-т заасан жагсаалтаар сонгох сонгуульд Монгол Улсын нутаг дэвсгэр сонгуулийн нэг тойрог байна.”

5/12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг:

“12.2. Энэ хуулийн 4.6-д заасны дагуу ээлжит бус сонгууль явуулах тохиолдолд Улсын Их Хурал ээлжит бус сонгуулийн санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө энэ хуульд нийцүүлэн сонгуулийн тойргийг байгуулна.”

6/14 дүгээр зүйлийн 14.5, 14.6 дахь хэсэг:

“14.5.Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороодын даргаар тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дарга, эсхүл Тамгын газрын даргын үүрэг гүйцэтгэгчийг томилно.

14.6.Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны төлөөлөл, цагдаагийн болон улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн байгууллагын дарга орсон байна.”

7/19¹ дүгээр зүйл:

“19¹ дүгээр зүйл.Гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажлыг зохион байгуулах төв болон салбар комиссын чиг үүрэг

19¹.1.Сонгуулийн ерөнхий хороо гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг харгалзан гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих үүрэг бүхий төв комиссыг гадаадад санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө дарга, нарийн бичгийн дарга болон ес, эсхүл арван нэгэн гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулна.

19¹.2.Төв комисс нь салбар комиссыг гадаадад санал авах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө дарга болон хоёр, эсхүл дөрвөн гишүүний бүрэлдэхүүнтэйгээр Дипломат төлөөлөгчийн газрын дэргэд байгуулна.

19¹.3.Төв комиссын дарга дотоод ажлын асуудлаар захирамж гаргана.

19¹.4.Төв комиссыг ажиллах байр, нөхцөл, боломжоор хангах үүргийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, салбар комиссыг ажиллах байр, нөхцөл, боломжоор хангах үүргийг тухайн улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар хүлээнэ.

19¹.5.Төв комисс нь Сонгуулийн ерөнхий хорооны шууд удирдлагын доор сонгуулийн санал авах ажлыг зохион байгуулна.

19¹.6.Салбар комисс нь төв комиссын шууд удирдлагын доор гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион байгуулна.

19¹.7.Төв комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:



19¹.7.1.гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг төлөвлөх, түүнийг зохион байгуулах арга хэмжээг авах;

19¹.7.2.эрх хэмжээнийхээ хүрээнд сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгаж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;

19¹.7.3.сонгууль зохион байгуулахтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооноос хуульд заасны дагуу өгсөн үүргийг биелүүлэх;

19¹.7.4.салбар комиссын үйл ажиллагааг зохион байгуулалт, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;

19¹.7.5.Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн саналын хуудас, сонгууль зохион байгуулах болон санал авахтай холбоотой бусад баримт бичгийг олон улсын буухиа шуудангаар салбар комисст хүргүүлэх;

19¹.7.6.шаардлагатай тохиолдолд салбар комисст сургалт зохион байгуулах, төлөөлөгч томилон ажиллуулах;

19¹.7.7.Сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, салбар комисст хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих, холбогдох журмын дагуу тайлагнах;

19¹.7.8.өөрийн эрх хэмжээнд хамаарах асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэж, бичгээр хариуг өгөх;

19¹.7.9.санал авах ажлыг зохион байгуулсан тухай тайлан, сонгуулийн бусад баримт бичиг, саналын хуудсыг Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх;

19¹.7.10.хуульд заасан бусад чиг үүрэг.

19¹.8.Салбар комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

19¹.8.1.салбар комиссын буюу санал авах байрны хаяг, ажиллах цагийн хуваарь, санал авах өдөр, цагийг сонгогчдод мэдээлэх;

19¹.8.2.өөрийн байрладаг улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэдийг бүртгэж, сонгогчдын бүртгэлийг гарган төв комисст хүргүүлэх;

19¹.8.3.санал авах байр, саналын хайрцаг, санал бэлтгэх бүхээг, санал авахад шаардлагатай бусад зүйлийг бэлтгэж, сонгогчдын санал авах ажлыг зохион байгуулах;

19¹.8.4.санал хураалт дууссаны дараа битүүмжилсэн дугтуйтай саналын хуудас, санал авахад зарцуулагдаагүй үлдсэн, хураагдсан, хүчингүй саналын хуудас, санал хураалтын тухай салбар комиссын хуралдааны тэмдэглэл, сонгуулийн бусад баримт бичгийг төв комисст олон улсын буухиа шуудангаар нэн даруй хүргүүлэх;

19¹.8.5.өөрийн эрх хэмжээнд хамаарах асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, бичгээр хариуг өгөх;

19¹.8.6.дээд шатны сонгуулийн байгууллагаас хуульд заасны дагуу өгсөн үүргийг биелүүлэх;

19¹.8.7.хуульд заасан бусад чиг үүрэг.”

8/20 дугаар зүйлийн 20.12, 20.13 дахь хэсэг:

“20.12.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20.9-д заасан хугацаанд хүргүүлсэн сонгогчдын нэрийн жагсаалтад энэ хуулийн 20.9.1, 20.9.3, 20.9.4, 20.9.5 дахь заалт, 23, 24 дүгээр зүйлд заасан үндэслэлээр оруулсан өөрчлөлт, гадаад улсад саналаа өгсөн сонгогчдын өөрчлөлтийг тусгаж сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтсээр дамжуулан хэсгийн хороонд хүргүүлнэ.

20.13.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуульд нийцүүлэн гадаад улсад байгаа иргэдийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, хүргүүлэх журмыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батална.”

9/20 дугаар зүйлийн 20.16 дахь хэсэг:

“20.16.Энэ хуульд заасан сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл ажиллагаа болон нэрийн жагсаалттай танилцах, ашиглах журмыг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нийцүүлэн, Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, тагнуулын байгууллага хамтран батална.”



10/20 дугаар зүйлийн 20.21, 20.22 дахь хэсэг:

“20.21.Энэ хуульд заасан журмын дагуу Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн нам, эвсэл, бие даан нэр дэвшигч, төрийн бус байгууллагын төлөөлөл сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх ажиллагаатай танилцаж болно.

20.22.Гадаад улсад байгаа иргэн гадаадад санал авах өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө сонгуульд оролцохоо мэдэгдэж, бүртгүүлнэ.”

11/23 дугаар зүйлийн 23.8 дахь хэсэг:

“23.8.Сонгуулийн ерөнхий хороо шаардлагатай гэж үзвэл сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой гомдол, мэдээллийн дагуу тухайн гомдол, мэдээллийг шалгахад шаардлагатай мэдээлэл, баримтыг холбогдох байгууллагаас гаргуулан авч, зөрчлийг арилгах асуудлаар эрх бүхий байгууллагад хугацаатай шаардлага хүргүүлэх эрхтэй.”

12/26 дугаар зүйлийн 26.3.9 дэх заалт:

“26.3.9.энэ хуулийн 26.2-т заасан шаардлагатай холбоотойгоор нам, намын даргын Улсын дээд шүүхийн лавлагаа, тамга, тэмдгийн улсын бүртгэлийн лавлагаа.”

13/28 дугаар зүйлийн 28.3.7 дахь заалт:

“28.3.7.сонгуулийн зардлын тайлан гаргах талаарх энэ хуульд заасан журмыг зөрчөөгүй.”

14/29 дүгээр зүйлийн 29.7 дахь хэсэг:

“29.7.Тойрогт болон жагсаалтад зэрэг нэр дэвшихийг хориглоно.”

15/29 дүгээр зүйлийн 29.10 дахь хэсэг:

“29.10.Нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ ардчилсан ёс, шударга ёсны зарчмыг баримталж, нийгмийн бүлгийн төлөөллийг харгалзана.”

16/30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэг:

“30.3.Нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ намын гишүүн, дэмжигчээсээ мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ, барьцаа, дэнчин авахыг хориглоно.”

17/30 дугаар зүйлийн 30.6 дахь хэсэг:

“30.6.Нам, эвсэл жагсаалтаар нэр дэвшүүлэхдээ 1:1 хүйсийн харьцаатай жагсаалтын дарааллыг үндэслэн нэр дэвшүүлнэ.”

18/31 дүгээр зүйлийн 31.5 дахь хэсэг:

“31.5.Бие даан нэр дэвшүүлэгч нь гарын үсэг зуруулахдаа А4 хэмжээнээс хэтрэхгүй хэмжээтэй өөрийн танилцуулах хуудсыг тарааж болно.”

19/33 дугаар зүйлийн 33.1.10 дахь заалт:

“33.1.10.энэ хуулийн 30.1, 30.2, 30.4, 30.6-д заасан нэр дэвшүүлэх ажиллагааны журам зөрчсөн бол нийт нэр дэвшигчийг, энэ хуулийн 29.7-д заасныг зөрчсөн бол тухайн нэр дэвшигчийг.”

20/37 дугаар зүйлийн 37.8 дахь хэсэг:

“37.8.Ухуулагч нь сайн дурын үндсэн дээр ажиллах бөгөөд урамшууллын хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувиас хэтрэхгүй байна.”

21/38 дугаар зүйлийн 38.13, 38.14 дэх хэсэг:

“38.13.Төрийн аудитын дээд байгууллага нь нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн энэ хуулийн 38.5-д заасан мөрийн хөтөлбөр, 38.7-д заасан хандивын тайланд тус бүр нэг дүгнэлт гаргана. Хандивын тайлан нь ээлжит сонгуулийн жилийн 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааг, ээлжит бус, нөхөн сонгуулийн тухайд тухайн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацааг хамаарна.

38.14.Төрийн аудитын дээд байгууллага энэ хуулийн 38.13-т заасан дүгнэлт гаргахад шаардлагатай лавлагааг холбогдох этгээдээс гаргуулан авах эрхтэй.”

22/39 дүгээр зүйлийн 39.7 дахь хэсэг:

“39.7.Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий радио, телевиз нь энэ хуулийн 39.5-д заасны дагуу нийтэд мэдээлсэн тайланг шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад нийтэд мэдээлснээс хойш ажлын 5 өдрийн дотор хүргүүлнэ.”

23/41 дүгээр зүйлийн 41.15, 41.16 дахь хэсэг:

“41.15.Сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материалыг бүхэлд нь брайль үсэгтэйгээр хэвлүүлж болно. Брайль үсэг бүхий хэвлэмэл материал энэ хуулийн 41 дүгээр зүйлд заасан хэмжээнд хамаарахгүй.

41.16.Нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны нэгдсэн хэвлэмэл материал нь гурван хэвлэлийн хуудаснаас хэтрэхгүй байна.”

24/46 дугаар зүйлийн 46.27, 46.28 дахь хэсэг:

“46.27.Нам, эвсэл, нэр дэвшигчийн бэлтгэсэн сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор хадмал тайлбар, эсхүл дохионы хэлний орчуулгатай байж болно.

46.28.Радио, телевизийн хүүхдэд зориулсан нэвтрүүлэг дундуур сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно.”

25/47 дугаар зүйлийн 47.12 дахь хэсэг:

“47.12.Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах зардал энэ хуулийн 50.1-д заасны дагуу тогтоосон зардлын дээд хэмжээний 15 хувиас хэтрэхгүй байна.”

26/48 дугаар зүйлийн 48.1.8 дахь заалт:

“48.1.8.тухайн жилийн төсөвт тусгаагүй нийгмийн халамж, хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлэх, амлалт өгөх, зарлах.”

27/48 дугаар зүйлийн 48.10 дахь хэсэг:

“48.10.Радио, телевиз нь сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал нам, эвслийн дарга, нэр дэвшигч оролцсон энэ хуульд зөвшөөрснөөс бусад хэлбэрийн бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, ярилцлага нэвтрүүлэхийг хориглоно.”

28/48 дугаар зүйлийн 48.16 дахь хэсэг:

“48.16.Харилцаа холбооны зохицуулах хороо энэ хуулийн 48.15-д заасан дүгнэлтийг үндэслэн тухайн телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр дамжих эрхийг дүгнэлтэд дурдсан хугацаагаар хязгаарлах арга хэмжээг авна.”

29/53 дугаар зүйлийн 53.4 дэх хэсэг:

“53.4.Энэ хуулийн 4.3.2-т заасан жагсаалтаар нэр дэвшигч нь нам, эвслийн сонгуулийн сурталчилгаанд зориулан хандив өгч болох бөгөөд нэг нэр дэвшигчийн өгсөн хандивын хэмжээ нь энэ хуульд заасны дагуу тогтоосон нэр дэвшигчээс тойрогт зарцуулах зардлын хэмжээний дунджаас хэтрэхгүй байна.”

30/59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг:

“59.4.Саналын хуудас нь дараах хэсэгтэй байна:

59.4.1.энэ хуулийн 4.3.1-д заасан сонгуулийн тойрогт нэр дэвшигчид өгсөн саналыг тэмдэглэх;

59.4.2.энэ хуулийн 4.3.2-т заасан нам, эвсэлд өгсөн саналыг тэмдэглэх.”

31/62 дугаар зүйлийн 62.12, 62.13 дахь хэсэг:

“62.12.Энэ хуулийн 62.11-д заасан хяналтын камерыг сонгогч саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэхэд саад учруулахгүйгээр байрлуулж, сонгогчийг бүртгэх болон санал өгөх орчинд явагдаж байгаа үйл ажиллагааг баримтжуулна.

62.13.Санал авах байранд байрлуулах хяналтын камерт тавигдах шаардлага, түүнийг байрлуулах, ашиглах болон бичлэгийг хадгалах, хамгаалах, устгах журмыг цагдаагийн төв байгууллага Сонгуулийн ерөнхий хороотой хамтран батална.”

32/64¹ дүгээр зүйл:

“64¹ дүгээр зүйл.Гадаад улсад байгаа иргэдийн санал авах газар, хугацаа

64¹.1.Гадаад улсад байгаа сонгогчийн саналыг энэ хуульд заасны дагуу тогтоосон санал авах өдөр, тухайн улсын орон нутгийн цагаар 07:00-22:00 цаг хүртэлх хугацаанд салбар комиссын тогтоосон санал авах байранд авна.

64¹.2.Салбар комисс нь санал авах өдөр, цаг, байрыг санал авах өдөр хүртэлх хугацаанд гадаад улсад байгаа сонгогчдод зарлан мэдээлнэ.

64¹.3.Сонгогчоос саналаа нууцаар өгөхөд шаардагдах санал бэлтгэх бүхээг бүхий байр, саналын хайрцгийг санал авах өдрөөс гурваас



доошгүй хоногийн өмнө энэ хуульд заасны дагуу тухайн улсад байгаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн хариуцаж, бэлтгэнэ.

64¹.4.Санал авах байранд сонгогчоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хүрэлцэхүйц тооны санал бэлтгэх бүхээг бэлтгэсэн байна.

64¹.5.Гадаад улсад байгаа сонгогчийн саналыг Сонгуулийн ерөнхий хорооноос хүргүүлсэн саналын хуудсаар авна.

64¹.6.Сонгуулийн ерөнхий хороо нь саналын хуудсыг уутны хамт битүүмжлэн, төв комиссоор дамжуулан гадаад улсад байгаа сонгогчдын санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө салбар комисст хүргүүлнэ.

64¹.7.Салбар комисс нь саналын хуудсыг бүрэлдэхүүнээрээ хүлээн авч, энэ тухай тэмдэглэл үйлдэж гарын үсэг зурна.”

33/65 дугаар зүйлийн 65.16, 65.17 дахь хэсэг:

“65.16.Бүртгэлийн хуудас авсан сонгогчийг сонгогчийн нэрийн жагсаалтын нэгдсэн санд бүртгэгдсэн тухай тэмдэглэгээ хийнэ.

65.17.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 65.6-д заасан сонгогчийн гарын хурууны хээгээр сонгогчдын нэрийн жагсаалтын нэгдсэн сантай тулган таниулах ажлыг хариуцна.”

34/66¹ дүгээр зүйл:

“66¹ дүгээр зүйл.Гадаад улсад байгаа сонгогч санал өгөх

66¹.1.Салбар комиссын бүрэлдэхүүн гадаадад санал авах өдөр тухайн улсын орон нутгийн цагаар 07:00 цагт ажиглагч, эсхүл сонгогчийн төлөөллийг байлцуулан саналын хайрцгийг нээж харуулан, шалган битүүмжилж, лацадсаны дараа салбар комиссын дарга дараах мэдээллийг хийж тэмдэглэл хөтлүүлнэ:

66¹.1.1.сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн нийт сонгогчийн тоо;

66¹.1.2.хүлээн авсан, алдагдаж үрэгдсэн, устгагдсан, үлдсэн саналын хуудасны тоо;

66¹.1.3.саналын хуудасны нэгдсэн дугаар.

66¹.2.Салбар комисс энэ хуулийн 66¹.1-д заасан ажиллагааг гүйцэтгэсний дараа санал авах ажиллагааг эхлүүлэх бөгөөд салбар комисс сонгогчийн иргэний үнэмлэх, эсхүл үндэсний гадаад паспортыг сонгогчдын нэрийн жагсаалттай тулган үзэж, сонгогч бүрд саналын хуудсыг дугуйн хамт олгоно.

66¹.3.Саналын хуудас авсан сонгогчоор сонгогчдын нэрийн жагсаалтад гарын үсэг зуруулна.

66¹.4.Энэ зүйлд өөрөөр заагаагүй бол гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажиллагаанд энэ хуулийн 65, 66 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

66¹.5.Салбар комисс санал авах ажиллагааны тухай тэмдэглэл хөтөлж бүх бүрэлдэхүүн гарын үсэг зурж, тэмдэг дарах бөгөөд уг тэмдэглэлд дараах мэдээллийг заавал тусгана:

66¹.5.1.сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн нийт сонгогчийн тоо;

66¹.5.2.саналын хуудас авсан сонгогчийн тоо;

66¹.5.3.саналын хуудас дахин авсан сонгогчийн тоо;

66¹.5.4.ажиглагчийн нэрс;

66¹.5.5.санал авах өдрийн үйл ажиллагааны талаарх

мэдээлэл.

66¹.6.Гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэн энэ хуулийн 59.4.2-т заасан хэсэгт саналаа өгнө.”

35/67 дугаар зүйлийн 67.15-67.19 дэх хэсэг:

“67.15.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагааг ажиглахтай холбогдсон харилцаанд сонгууль ажиглах ерөнхий журмыг баримтална.

67.16.Ажиглагч томилох эрх бүхий этгээд гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагаанд хоёр хүртэл ажиглагчийг томилон ажиллуулж болно.

67.17.Ажиглагч томилох эрх бүхий этгээд гадаад улсад байгаа сонгогчдоос санал авах ажиллагаанд ажиглагч томилох бол энэ тухай хүсэлтээ төв комисст гадаадад санал авах өдрөөс долоогоос доошгүй хоногийн өмнө хүргүүлнэ.



67.18.Төв комисс нь гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагааг ажиглахаар томилогдсон ажиглагчийн мэдээллийг холбогдох салбар комисст хүргүүлэх бөгөөд ажиглагч нь гадаадад санал авах өдрөөс өмнө салбар комисст бүртгүүлж, ажиглагчийн үнэмлэх авна.

67.19.Сонгогчийг санал өгсний дараа өгсөн саналынх нь талаар асуухыг хориглоно.”

36/68 дугаар зүйлийн 68.4 дэх хэсэг:

“68.4.Энэ хуульд заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн төрийн бус байгууллага нь нэр дэвшигч, нам, эвслийн сонгуулийн зардлын тайлан, түүнд холбогдох баримттай танилцах, хөндлөнгийн хяналт тавих эрхтэй.”

37/71 дүгээр зүйлийн 71.8.4 дэх заалт:

“71.8.4.нам, эвсэл бүрийн авсан саналын тоо.”

38/72¹ дүгээр зүйл:

“72¹ дүгээр зүйл.Гадаад улсад байгаа иргэдээс авсан саналыг тоолох

72¹.1.Гадаад улсад байгаа иргэдийн санал тоолох ажиллагааг Сонгуулийн ерөнхий хороо гүйцэтгэнэ.

72¹.2.Сонгуулийн ерөнхий хороо санал тоолох ажиллагааг өөрийн байранд санал авах өдрийн 22:00 цагт эхэлж, ажиглагч, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг байлцуулан ил тод, нээлттэй явуулна.

72¹.3.Сонгуулийн ерөнхий хороо дараах ажиллагааг гүйцэтгэсний дараа саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжид хийж саналыг тоолон санал хураалтын дүнг гаргаж нэн даруй мэдээлнэ:

72¹.3.1.төв комиссоос ирүүлсэн саналын хуудас бүхий битүүмжилсэн дугтуйн нийт тоо нь санал авахад олгосон саналын хуудасны тоотой тохирч байгаа эсэхийг тулган шалгаж, эцсийн тооцоо гаргах;

72¹.3.2.санал авахад зарцуулаагүй үлдсэн болон буруу тэмдэглэл хийснээс хураагдсан саналын хуудсыг тус тусад нь тоолох;

72¹.3.3.битүүмжилсэн дугтуйнуудыг нээж, саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжид хийхэд бэлэн болгох.

72¹.4.Гадаад улсад байгаа иргэдийн санал тоолох, дүн дамжуулах ажиллагааг явуулахад тухайн салбар комисст санал тоолох төхөөрөмжийг Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрээр хэрэглэж болно.”

39/74 дүгээр зүйлийн 74.3 дахь хэсэг:

“74.3.Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 4.3.2-т заасан жагсаалтаар нэр дэвшигчийн санал хураалтын дүнг дараах байдлаар гаргана:

74.3.1.санал хураалтын дүнг үндэслэн нам, эвсэл тус бүрээр авсан саналынх нь тоо, хувиар дараалалд оруулан жагсаалт гаргана;

74.3.2.энэ хуулийн 74.2-т заасан шаардлага хангасан нам, эвслийн авсан саналын хувь болон нийт нам, эвсэлд өгсөн хүчинтэй саналын хувь хоорондын зөрүүг энэ хуулийн 74.2-т заасан шаардлага хангасан нам, эвсэлд тэнцүү хэмжээгээр хуваан нам, эвсэл тус бүрийн авсан саналын хувь дээр нэмж тооцно;

74.3.3.энэ хуулийн 74.3.2-т заасны дагуу тооцож гаргасан хувиудын нийлбэрийг 48-д хувааж нэг суудалд ногдох саналын тоо, хувийг тооцож гаргана;

74.3.4.энэ хуулийн 74.3.2-т заасны дагуу тооцож гаргасан нам, эвсэл тус бүрийн авсан саналын хувийг энэ хуулийн 74.3.3-т заасны дагуу тооцож гаргасан нэг суудалд ногдох саналын хувьд хувааж, Улсын Их Хурлын гишүүний 48 суудлыг их үлдэгдлийн зарчмаар хувь тэнцүүлэн хуваарилна;

74.3.5.энэ хуулийн 74.3.4-т заасны дагуу нэг суудалд ногдох саналын хувьд хуваахдаа бутархай нарийвчлалтай гаргаж, эхний ээлжид бүхэл хэсэгт нь тэнцэх суудлыг хуваарилах, хэрэв хуваарилагдаагүй суудал үлдвэл хамгийн их үлдэгдэлтэйгээс нь эхлэн нэг нэгээр суудлыг нам, эвсэлд нэмж хуваарилах зарчмаар бүх суудлыг хуваарилж дуусгана;

Тайлбар: “хуваарилагдаагүй суудал” гэж энэ хуулийн 74.3.4-т заасны дагуу нам, эвслийн авсан саналын бүхэл хэсэгт нь ногдох суудал хуваарилахад суудал хуваарилагдаагүй үлдсэн, мөн нам, эвслийн авсан саналд ногдох суудлын тоо нь тухайн нам, эвслийн жагсаалтаар нэр дэвшигчийн тооноос их тооцогдсоны улмаас суудал хуваарилагдаагүй үлдэхийг ойлгоно.

74.3.6.Сонгуулийн ерөнхий хороо энэ хуульд заасны дагуу нам, эвслээс ирүүлсэн нэр дэвшигчдийн жагсаалтыг үндэслэн энэ

хуулийн 74.3.4-т заасны дагуу хуваарилсан суудлын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцно.”

40/77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсэг:

“77.2.Энэ хуулийн 4.3.1-д заасан сонгуулийн тойрогт нэр дэвшиж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүний орон гарсан, мөн энэ хуулийн 77.1-д заасны дагуу сонгогдсон тооцох дараагийн нэр дэвшигч үлдээгүй бол нөхөн сонгууль явагдана.”

41/81 дүгээр зүйлийн 81.8 дахь хэсэг:

“81.8.Шүүх энэ хуулийн 81.3-т заасны дагуу маргаан хянан шийдвэрлэхдээ захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэхгүй.”

2 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийн “2” гэсний дараа “, 3” гэж, мөн зүйлийн 4.7 дахь хэсгийн “Нөхөн сонгууль” гэж” гэсний дараа “энэ хуулийн 77.2-т заасны дагуу” гэж, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “Ээлжит” гэсний дараа “болон ээлжит бус” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын “хороо” гэсний дараа “, төв комисс, салбар комисс” гэж, мөн зүйлийн 10.1.3 дахь заалтын “программ хангамж” гэсний дараа “, сонгогч санал өгснийг тэмдэглэх бэх, түүний дагалдах хэрэгсэл,” гэж, мөн зүйлийн 10.1.4 дэх заалтын “тээвэрлэх” гэсний дараа “, энэ хуульд заасан олон улсын буухиа шуудангийн” гэж, мөн зүйлийн 10.4 дэх хэсгийн “дээд байгууллага” гэсний дараа “, батлан хамгаалах болон архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, улсын хил хамгаалах” гэж, “захиргааны байгууллага” гэсний дараа “, сум, дүүрэг” гэж, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “болон хэсгийн хороо” гэсний дараа “, төв комисс, салбар комисс” гэж, мөн зүйлийн 14.3 дахь хэсгийн “хороодод” гэсний дараа “нээлттэй” гэж, 20 дугаар зүйлийн 20.14 дэх хэсгийн “хэлбэртэй” гэсний дараа “нэгдсэн нэг сантай” гэж, мөн зүйлийн 20.16 дахь хэсгийн “байгууллага” гэсний дараа “Сонгуулийн ерөнхий хороотой хамтран” гэж, “нийцүүлэн” гэсний дараа “, Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн тагнуулын байгууллагатай хамтран” гэж, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “гомдлоо” гэсний дараа “итгэмжлэгдсэн ажилтан, эсхүл” гэж, “бичгээр” гэсний дараа “болон цахимаар” гэж, мөн зүйлийн 23.2 дахь хэсгийн “иргэний мэдээллийн талаар” гэсний дараа “болон иргэний улсын бүртгэлтэй холбоотой өөрчлөлтийн талаар” гэж, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “тухай” гэсний дараа “зөвхөн нэг” гэж, мөн зүйлийн 26.3.8, 26.4.8 дахь заалтын “хороотой харилцах” гэсний дараа “, нэр дэвшигчдийн бүртгэлийн асуудлыг хариуцан ажиллах” гэж, мөн зүйлийн 26.4 дэх хэсгийн “хүсэлтдээ” гэсний дараа “энэ хуулийн 26.3.9-д заасан лавлагаа болон” гэж, 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсгийн “эвсэл”



гэсний дараа “тойрог” гэж, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн “иргэн” гэсний дараа “сонгуулийн тойрог” гэж, 32 дугаар зүйлийн 32.2.1 дэх заалтын “шийдвэр,” гэсний дараа “сонгуулийн тойрогт нэр дэвшигчдийн жагсаалт болон жагсаалтаар нэр дэвшүүлсэн” гэж, 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсгийн “туслагч,” гэсний дараа “нийслэл болон аймгийн төвд 400 сонгогч тутамд нэг ухуулагч, бусад газарт” гэж, 41 дүгээр зүйлийн 41.1.3 дахь заалтын “ухуулах” гэсний дараа “буюу зурагт” гэж, мөн зүйлийн 41.2 дахь хэсгийн “эвслийн” гэсний дараа “тойрогт” гэж, 46 дугаар зүйлийн 46.2, 46.3, 46.4 дэх хэсгийн “сурталчилгааны” гэсний дараа “болон мэтгэлцээний” гэж, 47 дугаар зүйлийн 47.7 дахь хэсгийн “хороо” гэсний дараа “, тагнуулын байгууллага,” гэж, 48 дугаар зүйлийн 48.11 дэх хэсгийн “48.9”, “48.8, 48.9” гэсний дараа “, 48.10” гэж, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсгийн “болон” гэсний дараа “тойрогт” гэж, 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсгийн “эвсэл болон” гэсний дараа “сонгуулийн тойрогт” гэж, 54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсгийн “эсхүл” гэсний дараа “сонгуулийн тойрогт” гэж, “хэтрүүлэхгүйгээр” гэсний дараа “сонгуулийн зардлын дансанд” гэж, 58 дугаар зүйлийн 58.1 дэх хэсгийн “нийтэд” гэсний дараа “мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд” гэж, 60 дугаар зүйлийн 60.1.3, 60.1.4 дэх заалтын “эвслээс” гэсний дараа “тойрогт” гэж, 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсгийн “баталж,” гэсний дараа “үнэт цаас хэвлэх тусгай зөвшөөрөлтэй, тагнуулын байгууллагаас олгосон аюулгүй байдлын гэрчилгээ бүхий хуулийн этгээдээр” гэж, мөн зүйлийн 61.6 дахь хэсгийн “байлцуулан” гэсний дараа “, цагдаагийн байгууллагын хяналттайгаар” гэж, 63 дугаар зүйлийн 63.7 дахь хэсгийн “дагуу” гэсний дараа “нийслэл, сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд” гэж, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийн “биечлэн өгнө.” гэсний дараа “Сонгогч саналын хуудаст бичигдсэн зааврын дагуу тэмдэглэгээ хийж саналаа өгнө.” гэж, 71 дүгээр зүйлийн 71.5.2 дахь заалтын “хураагдсан саналын хуудасны” гэсний дараа “тоо нь тухайн хэсгийн хорооны хүлээн авсан саналын хуудасны” гэж, мөн зүйлийн 71.8.2 дахь заалтын “нэр дэвшигч” гэсний өмнө “тойрогт” гэж, мөн зүйлийн 71.16 дахь хэсгийн “байгууллагын” гэсний дараа “болон сонгогчдын” гэж, 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсгийн “тэмдэглэсэн” гэсний дараа “, нам, эвслийн санал тэмдэглэх хэсэгт нэгээс илүү нам, эвсэлд санал тэмдэглэсэн” гэж, 77 дугаар зүйлийн гарчгийн “явуулах” гэсний дараа “, орон гарсан суудлыг нөхөх” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/4 дүгээр зүйлийн 4.2, 4.3 дахь хэсэг:

“4.2. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг

төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно.

4.3.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын 126 гишүүнийг дараах байдлаар сонгоно:

4.3.1.Улсын Их Хурлын 78 гишүүнийг энэ хуульд заасны дагуу байгуулагдсан сонгуулийн тойргоос олныг төлөөлөх /мажоритар/ аргаар;

4.3.2.Улсын Их Хурлын 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх /пропорционал/ аргаар.

Тайлбар: -“олныг төлөөлөх /мажоритар/ арга” гэж тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү бөгөөд хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцохыг ойлгоно.

-“хувь тэнцүүлэн төлөөлөх /пропорционал/ арга” гэж сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийн авсан саналынх нь тоо, хувьд үндэслэн энэ хуульд заасны дагуу суудал хуваарилж, Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцохыг ойлгоно.”

2/25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг:

“25.1.Иргэний шилжилт хөдөлгөөнийг санал авах өдрөөс 60 хоногийн өмнө зогсоож, санал авах өдрийн дараах өдрөөс сэргээнэ.”

3/30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг:

“30.1.Нам, эвсэл нь 78 хүртэл хүнийг энэ хуульд заасны дагуу байгуулагдсан сонгуулийн тойрогт, 48 хүртэл хүнийг нам, эвслийн нэр дэвшигчдийн жагсаалтаар тус тус нэр дэвшүүлнэ.”

4/42 дугаар зүйл:

“42 дугаар зүйл.Сонгуулийн сурталчилгаанд зурагт самбар ашиглах

42.1.Тойрогт нэр дэвшигчдийн зурагт хуудсыг байрлуулсан нэгдсэн самбар /цаашид “нэгдсэн самбар” гэх/-ыг сум, дүүргийн Засаг дарга дараах шаардлагын дагуу бэлтгэж, байршуулах ажлыг зохион байгуулна:

42.1.1.нэр дэвшигчийн зурагт хуудас нь нэг хэвлэлийн хуудасны дөрөвний нэг хэмжээтэй байх;

42.1.2.зурагт хуудас байрлуулах дарааллыг энэ хуулийн 60 дугаар зүйлд заасныг үндэслэн тогтоох;

42.1.3.сонгогчийн тоонд үндэслэн суманд хоёр хүртэл, аймгийн төвийн суманд тав хүртэл, хороонд дөрөв хүртэл нэгдсэн самбарыг үнэ төлбөргүй байрлуулах.

42.2.Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага нь найман хэвлэлийн хуудаснаас илүүгүй хэмжээтэй зурагт самбарыг суманд нэг, хороонд хоёр хүртэл байрлуулж болно.

42.3.Зурагт самбарыг зөвхөн нийтийн эзэмшлийн газар буюу гудамж, талбайд сурталчилгааны хугацаанд түр хугацаагаар, үнэ төлбөргүй байрлуулна. Зурагт самбарт тухайн нам, эвслийн нэрийг дурдсан байна.

42.4.Бизнесийн зорилгоор байнга ашиглагддаг сурталчилгааны самбар, дэлгэц, түүний орон зайг сонгуулийн сурталчилгаанд ашиглахгүй.

42.5.Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, нэр дэвшигчийн ухуулах байр байрлаж байгаагаас бусад байшин, барилга байгууламжид сонгуулийн сурталчилгааны самбар байрлуулахгүй.

42.6.Нэгдсэн самбар болон зурагт самбар байрлуулахдаа замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрлэн дохио, хөдөлгөөн зохицуулах бусад хэрэгслийг халхлах, бусдын эд хөрөнгө, явган зорчигчдод аюул учруулж болзошгүй байдлаар байрлуулах, замын хөдөлгөөнд саад учруулахыг хориглоно.”

5/48 дугаар зүйлийн 48.9 дэх хэсэг:

“48.9.Нам, эвслийн дарга, нэр дэвшигч нь сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал сонгуулийн сурталчилгааны бус бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, ярилцлагад орох, нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигч ухуулах байр ажиллуулахыг хориглоно.”

6/50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсэг:

“50.2.Сонгуулийн зардлын дээд хэмжээ тогтоох аргачлал нь сонгуулийн зардлыг бууруулахад чиглэх бөгөөд сонгуулийн нутаг дэвсгэрийн хэмжээ, байршил, өрхийн болон сонгогчийн тоо, энэ хуульд заасан бусад шаардлагад үндэслэнэ. Аргачлалыг төрийн аудитын дээд байгууллагын саналаар Сонгуулийн ерөнхий хороо батална.”

7/62 дугаар зүйлийн 62.11 дэх хэсэг:

“62.11.Санал авах байрны хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах зорилгоор санал авах байранд хяналтын камер байрлуулна. Төв суурин газраас алслагдсан баг дахь санал авах байранд хяналтын камер байрлуулж болно.”

8/65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг:

“65.6.Санал авах байранд ажиллаж байгаа итгэмжлэгдсэн ажилтан сонгогчийн гарын хурууны хээг сонгогчдын нэрийн жагсаалтын цахим хувилбартай тулгаж, энэ хуулийн 66.5-д заасан бэхэн тэмдэглэгээ хийгдсэн эсэхийг нягтлан, зөрчилгүй бол сонгогчийн бүртгэлийн хуудас олгоно.”

9/66 дугаар зүйлийн 66.2 дахь хэсэг:

“66.2.Сонгогч энэ хуулийн 59.4.2-т заасан хэсэгт нэг нам, эвсэлд саналаа өгнө.”

10/66 дугаар зүйлийн 66.5 дахь хэсэг:

“66.5.Сонгогч саналын хуудсаа санал тоолох төхөөрөмж /саналын хайрцаг-д хийсний дараа тухайн сонгогч саналаа өгснийг илэрхийлэх бэхэн тэмдэглэгээг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан зааврын дагуу хийнэ.”

11/71 дүгээр зүйлийн 71.14 дэх хэсэг:

“71.14.Санал авах ажиллагаа дууссаны дараа бүх хэсэгт хяналтын тооллого хийнэ.”

12/74 дүгээр зүйлийн 74.1-74.3 дахь хэсэг:

“74.1.Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 4.3.1-д заасан сонгуулийн тойрогт нэр дэвшигчийн санал хураалтын дүнг дараах байдлаар гаргана:

74.1.1.Сонгуулийн ерөнхий хороо нь санал хураалтын дүнг үндэслэн тухайн тойрогт нэр дэвшсэн нийт нэр дэвшигчдийг авсан саналынх нь тоогоор дараалалд оруулан жагсаалт гаргана;

74.1.2.хамгийн олон санал авсан, тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцно.

74.2. Дараах шаардлагыг хангасан нам, эвсэлд энэ хуульд заасны дагуу суудал хуваарилна:

74.2.1. энэ хуулийн 4.3.1-д заасан тойрогт ногдох нийт мандатын 50 буюу түүнээс дээш хувьд нь нэр дэвшүүлсэн байх;

74.2.2. намын тухайд нам, эвсэлд өгсөн нийт саналын 4 буюу түүнээс дээш хувийн санал авсан байх;

74.2.3. хоёр нам бүхий эвслийн тухайд нам, эвсэлд өгсөн нийт саналын 5 буюу түүнээс дээш хувийн санал авсан байх;

74.2.4. гурав буюу түүнээс дээш нам бүхий эвслийн тухайд нам, эвсэлд өгсөн нийт саналын 7 буюу түүнээс дээш хувийн санал авсан байх.

74.3. Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 74.1, 74.3-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай шийдвэр гаргаж, Улсын Их Хурлын гишүүний үнэмлэх олгож, нийтэд мэдээлнэ.”

13/77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг:

“77.1. Энэ хуулийн 4.3.2-т заасан жагсаалтаар нэр дэвшиж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүний орон гарсан бол тухайн нам, эвслийн жагсаалтын дараагийн нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай шийдвэрийг Сонгуулийн ерөнхий хороо орон гарснаас хойш 14 хоногийн дотор гаргаж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.”

4 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3, 5.4, 5.5 дахь хэсгийн дугаарыг “5.3, 5.4, 5.5, 5.6” гэж, 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсгийн “ажлын долоон өдөрт багтаан” гэснийг “10 хоногийн дотор” гэж, мөн зүйлийн 9.3, 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9, 9.10 дахь хэсгийн дугаарыг “9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9, 9.10, 9.11” гэж, мөн зүйлийн 9.5 дахь хэсгийн “9.4-т” гэснийг “9.5-д” гэж, мөн зүйлийн 9.6 дахь хэсгийн “9.4, 9.5-д” гэснийг “9.5, 9.6-д” гэж, мөн зүйлийн 9.7 дахь хэсгийн “9.6-д” гэснийг “9.7-д” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтын “дүнгийн” гэснийг “дүн болон ирцийн” гэж, мөн зүйлийн 10.1.7 дахь заалтын “хэмжээний” гэснийг “хэмжээ, түүнд холбогдох тоног төхөөрөмж, ажил, үйлчилгээний” гэж, 10.1.14 дэх заалтын “46, 47, 48.9-д” гэснийг “46, 47 дугаар зүйл, 48.9, 48.10-т” гэж, мөн зүйлийн 10.1.14, 10.1.15 дахь заалтын дугаарыг “10.1.15, 10.1.16” гэж, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “Сонгуулийн” гэснийг “Энэ хуулийн 4.3.1-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнийг сонгох сонгуулийн” гэж, 12 дугаар зүйлийн 12.5 дахь

хэсгийн “Ээлжит сонгуулиар байгуулагдсан сонгуулийн тойргийг” гэснийг “Сонгуулийн тойргийг ээлжит бус сонгууль явуулахаас бусад тохиолдолд” гэж, мөн зүйлийн 12.2, 12.3, 12.4, 12.5 дахь хэсгийн дугаарыг “12.3, 12.4, 12.5, 12.6” гэж, 13 дугаар зүйлийн 13.1, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “нутаг дэвсгэр, төвийг” гэснийг “нутаг дэвсгэрийг” гэж, мөн зүйлийн 13.6, 13.7 дахь хэсгийн “тав” гэснийг “гурав” гэж, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “хороог” гэснийг “хороо, гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион байгуулах төв болон салбар комиссыг” гэж, мөн зүйлийн 14.19 дэх хэсгийн “14.10-т” гэснийг “14.12-т” гэж, мөн зүйлийн 14.5, 14.6, 14.7, 14.8, 14.9, 14.10, 14.11, 14.12, 14.13, 14.14, 14.15, 14.16, 14.17, 14.18, 14.19 дэх хэсгийн дугаарыг “14.7, 14.8, 14.9, 14.10, 14.11, 14.12, 14.13, 14.14, 14.15, 14.16, 14.17, 14.18, 14.19, 14.20, 14.21” гэж, 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсгийн “жагсаалтаас өөрт нь холбогдох” гэснийг “жагсаалт дахь өөрийн болон өөрийн байнга оршин суугаа хаягийн бүртгэлд бүртгэгдсэн нийт сонгогчийн” гэж, мөн зүйлийн 20.6 дахь хэсгийн “Сонгуулийн ерөнхий хороонд” гэснийг “улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад” гэж, мөн зүйлийн 20.10 дахь хэсгийн “сонгогч өөрт нь холбогдох” гэснийг “итгэмжлэгдсэн ажилтныг ажиллуулж, сонгогчдод өөрийн болон өөрийн байнга оршин суугаа хаягийн бүртгэлд бүртгэгдсэн нийт сонгогчийн” гэж, мөн зүйлийн 20.13 дахь хэсгийн “цахим хэлбэрээр нэг удаа” гэснийг “болон санал авах өдрөөс 3 хоногийн өмнө тус тус цахим хэлбэрээр” гэж, мөн зүйлийн 20.15 дахь хэсгийн “хувилж олшруулах,” гэснийг “энэ хуульд зааснаас бусад тохиолдолд хэвлэж” гэж, мөн зүйлийн 20.12, 20.13 дахь хэсгийн дугаарыг “20.14, 20.15” гэж, мөн зүйлийн 20.14, 20.15, 20.16, 20.17 дахь хэсгийн дугаарыг “20.17, 20.18, 20.19, 20.20” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “20” гэснийг “7” гэж, мөн зүйлийн 21.2 дахь хэсгийн “50” гэснийг “14” гэж, мөн зүйлийн 21.3 дахь хэсгийн “40-өөс доошгүй хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хороонд” гэснийг “45-аас доошгүй хоногийн өмнө улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад” гэж, мөн зүйлийн 21.6 дахь хэсгийн “хуулийн 21.5-д заасны дагуу” гэснийг “хуульд заасан” гэж, “15-аас” гэснийг “5-аас” гэж, 26 дугаар зүйлийн 26.4.9 дэх заалтын “гэрээний хуулбар” гэснийг “гэрээ” гэж, 29 дүгээр зүйлийн 29.7, 29.8 дахь хэсгийн дугаарыг “29.8, 29.9” гэж, 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн “нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчийн 20-оос доошгүй” гэснийг “нэр дэвшүүлэхэд 2024 оны ээлжит сонгуулиар нийт нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь нь, 2028 оны ээлжит сонгуулиар 40-өөс доошгүй” гэж, мөн зүйлийн 30.3, 30.4 дэх хэсгийн дугаарыг “30.4, 30.5” гэж, 32 дугаар зүйлийн 32.11 дэх хэсгийн “хүлээн авснаас хойш тав” гэснийг “хүлээн авах хугацаа дууссанаас хойш долоо” гэж, мөн зүйлийн 32.12, 38 дугаар зүйлийн 38.12 дахь хэсгийн “22” гэснийг “18” гэж, 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсгийн “100 хүртэл, нийслэлд 20 хүртэл, аймаг,” гэснийг “500 хүртэл, аймаг, нийслэлд 100 хүртэл,” гэж, 38 дугаар зүйлийн 38.10 дахь хэсгийн “энэ хуульд заасан шаардлагад нийцэж байгаа эсэх талаарх” гэснийг “болон хандивын тайланд хийсэн” гэж, 38 дугаар зүйлийн 38.7, 38.8,

38.12 дахь хэсгийн “26.3.6, 26.4.6-д” гэснийг “38.13-т” гэж, 39 дүгээр зүйлийн 39.5 дахь хэсгийн “явуулсан хэвлэл мэдээллийн” гэснийг “нэвтрүүлэх эрх бүхий радио, телевизийн үйлчилгээ эрхлэгч” гэж, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “Нэр дэвшигч нь” гэснийг “Сонгуулийн тойрогт нэр дэвшигч нь” гэж, “дөрвөөс” гэснийг “хоёроос” гэж, 41 дүгээр зүйлийн 41.1.1, 41.1.2 дахь заалтын “гурван” гэснийг “хоёр” гэж, мөн зүйлийн 41.3 дахь хэсгийн “Ухуулах хуудас болон зурагт” гэснийг “Зурагт” гэж, мөн зүйлийн 41.11 дэх хэсгийн “нам, эвсэл, нэр дэвшигчийн зурагт болон ухуулах хуудсыг” гэснийг “зурагт самбарыг” гэж, 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсгийн “тогтоосон” гэснийг “баталсан” гэж, мөн зүйлийн 46.4 дэх хэсгийн “үзсэний үндсэн дээр сонгуулийн” гэснийг “үзэж, сурталчилгааны болон мэтгэлцээний нэвтрүүлгийн хуваарь, цагийг тэнцүү байхаар тооцож” гэж, мөн зүйлийн 46.9.1 дэх заалтын “тогтоосон нарийвчилсан” гэснийг “төлөвлөсөн” гэж, мөн зүйлийн 46.9.3 дахь заалтын “дундаж үнийн талаарх мэдээлэл” гэснийг “үнийн санал” гэж, мөн зүйлийн 46.11 дэх хэсгийн “зөвхөн үндсэн” гэснийг “аль нэг” гэж, мөн зүйлийн 46.20 дахь хэсгийн “журмыг Сонгуулийн ерөнхий хороо, Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран энэ хуульд нийцүүлэн” гэснийг “, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журмыг Харилцаа холбооны зохицуулах хорооны саналыг үндэслэн, энэ хуульд нийцүүлэн Сонгуулийн ерөнхий хороо” гэж, 48 дугаар зүйлийн 48.1.7 дахь заалтын “байгуулах.” гэснийг “байгуулах, нийтлэх;” гэж, мөн зүйлийн 48.14 дэх хэсгийн “48.12-т” гэснийг “48.13-т” гэж, мөн зүйлийн 48.10, 48.11, 48.12, 48.13, 48.14 дэх хэсгийн дугаарыг “48.11, 48.12, 48.13, 48.14, 48.15” гэж, 51 дүгээр зүйлийн 51.4 дэх хэсгийн “20-оос” гэснийг “15-аас” гэж, 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсгийн “таван” гэснийг “арван” гэж, “хорин” гэснийг “гучин” гэж, 58 дугаар зүйлийн 58.3 дахь хэсгийн “26.3.6, 26.4.6, 38.5-д” гэснийг “38.5, 38.13-т” гэж, 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсгийн “тэдгээрийн нэр дэвшигч, бусад” гэснийг “тэдгээрээс тойрогт нэр дэвшигч, бие даан” гэж, 63 дугаар зүйлийн 63.1.3 дахь заалтын “зөрчлийн улмаас” гэснийг “захиргааны журмаар албадан эмчлүүлж байгаа болон зөрчлийн хэрэгт холбогдуулан” гэж, мөн зүйлийн 63.5 дахь хэсгийн “байгууллагын нутаг дэвсгэрийн хувьд” гэснийг “сонгогчийн” гэж, 66 дугаар зүйлийн 66.13.3 дахь заалтын “саналаа болон бусад сонгогчийн саналыг баримтжуулан” гэснийг “санал, саналын хуудасны” гэж, мөн зүйлийн 66.13.5 дахь заалтын “дэвшигчийн” гэснийг “дэвшигч, нам, эвслийн” гэж, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсгийн “дөрөв” гэснийг “хоёр” гэж, мөн зүйлийн 67.7 дахь хэсгийн “таваас” гэснийг “долоогоос” гэж, мөн зүйлийн 67.9 дэх хэсгийн “хоёроос” гэснийг “таваас” гэж, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсгийн “Сонгуулийн санал авах өдөр санал тоолох” гэснийг “Санал тоолох” гэж, 71 дүгээр зүйлийн 71.10 дахь хэсгийн “дэвшигчийн” гэснийг “дэвшигч, эсхүл нам, эвслийн” гэж, 74 дүгээр зүйлийн 74.3, 74.4 дэх хэсгийн дугаарыг “74.4, 74.5” гэж, 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсгийн “зургаан сар” гэснийг “нэг жил” гэж, мөн зүйлийн 77.2, 77.3, 77.4 дэх хэсгийн дугаарыг “77.3, 77.4, 77.5” гэж, 81 дүгээр зүйлийн 81.3 дахь хэсгийн “хуульд” гэснийг “хуулийн 74 дүгээр зүйлд” гэж тус тус өөрчилсүгэй.



5 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9 дэх заалтын “болон цахим орчин дахь олон нийтийн сүлжээг” гэснийг, 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн “улсын төсвөөс санхүүжих” гэснийг, 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсгийн “. Сонгуулийн ерөнхий хороо уг мэдээллийг хүлээн авснаас хойш гурав хоногийн дотор улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ” гэснийг, мөн зүйлийн 20.6.2 дахь заалтын “, захиргааны журмаар албадан эмчлүүлж байгаа болон зөрчлийн хэрэгт холбогдуулан баривчлагдсан” гэснийг, мөн зүйлийн 20.7 дахь хэсгийн “, 20.6.7, 20.6.8” гэснийг, мөн зүйлийн 20.9.3 дахь заалтын “, иргэний бүртгэлийн дугаар” гэснийг, 35 дугаар зүйлийн 35.2.1 дэх заалтын “саатуулах, албадан саатуулах,” гэснийг, 41 дүгээр зүйлийн 41.5 дахь хэсгийн “, ухуулах хуудас” гэснийг, 46 дугаар зүйлийн 46.17 дахь хэсгийн “талаарх” гэснийг, 48 дугаар зүйлийн 48.5 дахь хэсгийн “сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд нь сонгуулийн” гэснийг, 71 дүгээр зүйлийн 71.15 дахь хэсгийн “Хяналтын тооллого хийхээр сонгогдсон хэсгийн хороо” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6.7 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсэг, 26 дугаар зүйлийн 26.3.3, 26.3.4, 26.3.6 дахь заалт, 26.4.3, 26.4.4, 26.4.5, 26.4.6 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.1.2, 27.1.3 дахь заалт, 27.7, 27.8 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.3.9 дэх заалт, 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх заалт, 41 дүгээр зүйлийн 41.6, 41.7, 41.12 дахь хэсэг, 63 дугаар зүйлийн 63.6.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.14 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



**Мэдээлэл болон
Холбоо**

МОНГОЛЫН
МОНГОЛЫН
МОНГОЛЫН

2023 оны 34 дүгээр тооноос
2023 оны 34 дүгээр тооноос

МОНГОЛЫН
МОНГОЛЫН
МОНГОЛЫН

МОНГОЛЫН
МОНГОЛЫН
МОНГОЛЫН

2023 оны 34 дүгээр тооноос

МОНГОЛЫН
МОНГОЛЫН
МОНГОЛЫН

2023 оны 34 дүгээр тооноос

МОНГОЛЫН
МОНГОЛЫН
МОНГОЛЫН

2023 оны 34 дүгээр тооноос

МОНГОЛЫН
МОНГОЛЫН
МОНГОЛЫН

2023.06.01-ийг хүлээн авч, үндсэн зар зориулалтуудыг өөрчлөх нь зүйлгүй байна.
Төлөвлөгөөний хөрөнгийн үндсэн зар зориулалтуудыг өөрчлөх нь зүйлгүй байна.

2023.06.01-ийг хүлээн авч, үндсэн зар зориулалтуудыг өөрчлөх нь зүйлгүй байна.
Төлөвлөгөөний хөрөнгийн үндсэн зар зориулалтуудыг өөрчлөх нь зүйлгүй байна.

2023.06.01-ийг хүлээн авч, үндсэн зар зориулалтуудыг өөрчлөх нь зүйлгүй байна.
Төлөвлөгөөний хөрөнгийн үндсэн зар зориулалтуудыг өөрчлөх нь зүйлгүй байна.

2023.06.01-ийг хүлээн авч, үндсэн зар зориулалтуудыг өөрчлөх нь зүйлгүй байна.
Төлөвлөгөөний хөрөнгийн үндсэн зар зориулалтуудыг өөрчлөх нь зүйлгүй байна.

2023.06.01-ийг хүлээн авч, үндсэн зар зориулалтуудыг өөрчлөх нь зүйлгүй байна.

2023.06.01-ийг хүлээн авч, үндсэн зар зориулалтуудыг өөрчлөх нь зүйлгүй байна.
Төлөвлөгөөний хөрөнгийн үндсэн зар зориулалтуудыг өөрчлөх нь зүйлгүй байна.

2023.06.01-ийг хүлээн авч, үндсэн зар зориулалтуудыг өөрчлөх нь зүйлгүй байна.
Төлөвлөгөөний хөрөнгийн үндсэн зар зориулалтуудыг өөрчлөх нь зүйлгүй байна.

2023.06.01-ийг хүлээн авч, үндсэн зар зориулалтуудыг өөрчлөх нь зүйлгүй байна.

« 2023 он...-ийн төсвийн зар зориулалтуудыг өөрчлөх нь зүйлгүй байна.»

3.6.6.1. Нийслэл хотод байрладаг үйлдвэр, ажлаас гарсан хатуу хаягдлыг хуримтлуулан, тусгай зориулалтын газруудад хаяхыг зохицуулах.

Урьдчилсан :

3.6.6.2. Үйлдвэр, ажлаас гарсан хатуу хаягдлыг хуримтлуулан, тусгай зориулалтын газруудад хаяхыг зохицуулах.

Мөнөөдөр :

3.6.6.3. Үйлдвэр, ажлаас гарсан хатуу хаягдлыг хуримтлуулан, тусгай зориулалтын газруудад хаяхыг зохицуулах.

3.6.6.4. Үйлдвэр, ажлаас гарсан хатуу хаягдлыг хуримтлуулан, тусгай зориулалтын газруудад хаяхыг зохицуулах.

3.6.6.5. Үйлдвэр, ажлаас гарсан хатуу хаягдлыг хуримтлуулан, тусгай зориулалтын газруудад хаяхыг зохицуулах.

3.6.6.6. Үйлдвэр, ажлаас гарсан хатуу хаягдлыг хуримтлуулан, тусгай зориулалтын газруудад хаяхыг зохицуулах.

3.6.6.7. Үйлдвэр, ажлаас гарсан хатуу хаягдлыг хуримтлуулан, тусгай зориулалтын газруудад хаяхыг зохицуулах.

3.6.6.8. Үйлдвэр, ажлаас гарсан хатуу хаягдлыг хуримтлуулан, тусгай зориулалтын газруудад хаяхыг зохицуулах.

3.6.6.9. Үйлдвэр, ажлаас гарсан хатуу хаягдлыг хуримтлуулан, тусгай зориулалтын газруудад хаяхыг зохицуулах.

3.6.6.10. Үйлдвэр, ажлаас гарсан хатуу хаягдлыг хуримтлуулан, тусгай зориулалтын газруудад хаяхыг зохицуулах.

3.6.6.11. Үйлдвэр, ажлаас гарсан хатуу хаягдлыг хуримтлуулан, тусгай зориулалтын газруудад хаяхыг зохицуулах.

3.6.6.12. Үйлдвэр, ажлаас гарсан хатуу хаягдлыг хуримтлуулан, тусгай зориулалтын газруудад хаяхыг зохицуулах.

3.6.6.13. Үйлдвэр, ажлаас гарсан хатуу хаягдлыг хуримтлуулан, тусгай зориулалтын газруудад хаяхыг зохицуулах.

3.6.6.14. Үйлдвэр, ажлаас гарсан хатуу хаягдлыг хуримтлуулан, тусгай зориулалтын газруудад хаяхыг зохицуулах.

3.6.6.15. Үйлдвэр, ажлаас гарсан хатуу хаягдлыг хуримтлуулан, тусгай зориулалтын газруудад хаяхыг зохицуулах.

3.6.6.16. Үйлдвэр, ажлаас гарсан хатуу хаягдлыг хуримтлуулан, тусгай зориулалтын газруудад хаяхыг зохицуулах.

3.6.6.17. Үйлдвэр, ажлаас гарсан хатуу хаягдлыг хуримтлуулан, тусгай зориулалтын газруудад хаяхыг зохицуулах.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 06 дугаар
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8 дахь хэсгийн “хяналтын дэд хорооны” гэсний дараа “, Сонгогчдын нэрийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны” гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Монгол Улсын Их Хурлын
Төрийн мэдээлэл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 06 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 42

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Д.Ганбат нараас 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг буцаах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Төрийн мэдээлэл
Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ
2023 оны 06 дугаар сарын 08-ны өдөр
Дугаар 42
Улаанбаатар хот

Төрийн мэдээлэл
Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурал



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 06 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 47

Улаанбаатар
хот

Засгийн газарт чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсантай холбогдуулан сонгуулийн зардлын ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг хангах, сонгуулийн холбогдолтой гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /Н.Энхболд/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Mongolian Folio on Yekhi Horik and Doodlegka

᠑᠙᠘᠘ он ᠑᠑ сар ᠑᠑ өдөр / 2023.11.11 - ᠑᠑ сар ᠑᠑ өдөр

᠑᠑ сар ᠑᠑ өдөр

᠑᠑ сар ᠑᠑ өдөр

᠑᠑ сар ᠑᠑ өдөр / 2023.11.11 - ᠑᠑ сар ᠑᠑ өдөр

᠑᠑ сар ᠑᠑ өдөр / 2023.11.11 - ᠑᠑ сар ᠑᠑ өдөр

᠑᠑ сар ᠑᠑ өдөр / 2023.11.11 - ᠑᠑ сар ᠑᠑ өдөр

᠑᠑ сар ᠑᠑ өдөр / 2023.11.11 - ᠑᠑ сар ᠑᠑ өдөр

᠑᠑ сар ᠑᠑ өдөр / 2023.11.11 - ᠑᠑ сар ᠑᠑ өдөр



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 02 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 60

Улаанбаатар
хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 20, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 24-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацааны нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан журмын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (Т.Аюурсайхан)-д үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 1994 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 212 дугаар тогтоол, “Зарим журам, дүрэм, тогтоолын заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах, тогтоол, тогтоолын заалт хүчингүй болсонд тооцох тухай” Засгийн газрын 1996 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 128 дугаар тогтоолын 1-3 дахь заалт, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2008 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн 26 дугаар тогтоол, “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Засгийн газрын 2015 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 318 дугаар тогтоол, “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 485 дугаар тогтоол, “Журамд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 207 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

Т.АЮУРСАЙХАН



Засгийн газрын 2023 оны 02 дугаар
сарын 08-ны өдрийн 60 дугаар
тогтоолын хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛСНӨӨР ТООЦГОДОХ ХУГАЦААНЫ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Нийгмийн даатгалын шимтгэл (цаашид "шимтгэл" гэх) төлснөөр тооцогдох хугацааны шимтгэл төлөхтэй холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Төр, ажил олгогчоос Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 1-8 дахь заалт, мөн зүйлийн 6 дахь хэсгийн 2, 3 дахь заалт, Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэг, мөн хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэг, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын хилийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 282 дугаар зүйлийн 282.7 дахь хэсэг, Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.3 дахь хэсэгт тус тус заасан дараах хугацааны шимтгэлийг нийгмийн даатгалын санд төлсөн тохиолдолд тухайн хугацааг шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцно:

1.2.1.хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч болон төрийн албан хаагч аж ахуйн нэгж, байгууллагын захиалгаар ажлаас чөлөөлөгдөж суралцсан хугацаа;

1.2.2.цэргийн жинхэнэ албыг байлдагч, түрүүчээр хаасан хугацаа;

1.2.3.эх, эсхүл эцгийн хүүхдээ гурван нас хүртэл асрах чөлөөтэй байсан хугацаа;

1.2.4.хууль бусаар ажлаас зайлуулагдан мөрдөгдсөн, хилс хэргээр хорих ял эдэлсэн хугацаа;

1.2.5.хууль бусаар ажлаас халагдсан хугацаа;

1.2.6.иргэний хамгаалалтын болон бусад дайчилгааны хугацаа;



1.2.7.нэг сараас дээш хугацаагаар хөдөлмөрийн чадвар түр алдсан хугацаа;

1.2.8.жирэмсний болон амаржсаны амралттай байсан хугацаа;

1.2.9.цаатан иргэний цаа буга маллан тайгад амьдарч байгаа хугацаа;

1.2.10.хуанлийн жилд 7 сараас доошгүй хугацаагаар улирлын чанартай ажил, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтны ажилгүй байсан хугацаа;

1.2.11.нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан, жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүссэн эхийн хүүхдээ 3 нас хүртэл асарсан хугацаа;

1.2.12.нийгмийн даатгалд албан журмаар болон сайн дураар даатгуулснаас бусад эхийн хүүхдээ 3 нас хүртэл асарсан хугацаа;

1.2.13.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэвэр авч байсан хугацаа;

1.2.14.дипломат төлөөлөгчийн газарт ажиллагчдын цаг уурын хүнд нөхцөл бүхий улсад ажилласан жилийн нэмэгдэл хугацаа;

1.2.15.дипломат төлөөлөгчийн газарт ажиллагчдын эхнэр буюу нөхрийн тодорхой ажил эрхлээгүй байсан хугацаа;

1.2.16.зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүх шинжилгээний болон авлигатай тэмцэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад генерал, комиссар, офицер, ахлагч, түрүүч, байлдагчаар 10-аас доош жил алба хаасан хугацаа;

1.2.17.улсын хил дээр алба хааж байгаа хилчний гэр бүлийг ажлаар хангаагүй нөхцөлд тэдний ажилгүй байсан хугацаа;

1.2.18.хил дээр ажиллаж байгаа гаалийн улсын байцаагчийн гэр бүлийг ажлаар хангаагүй нөхцөлд тэдний ажилгүй байсан хугацаа;

1.2.19.цагдаагийн алба хаагч шилжин ажиллах болсноос шалтгаалан хөдөлмөрийн гэрээгээ цуцлахад хүрсэн эхнэр, нөхрийг ажлаар хангаагүй нөхцөлд тэдний ажилгүй байсан хугацаа.

1.3.Төр, ажил олгогчоос энэ журмын дагуу төлөх шимтгэлд шаардагдах зардлыг улсын төсөв, нийгмийн даатгалын сангийн төсөв, байгууллагын төсөвт тусгах ажлыг холбогдох төрийн захиргааны төв болон бусад байгууллага хариуцан гүйцэтгэнэ.

Хоёр.Шимтгэл төлснөөр тооцогдох хугацааны шимтгэл төлөх

2.1.Ажил олгогч шимтгэл төлснөөр тооцогдох дараах хугацааны шимтгэлийг нийгмийн даатгалын санд доор дурдсанаар төлнө:

2.1.1.энэ журмын 1.2.1-д заасан хугацааны тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын шимтгэлийг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн төлбөл зохих хувиар тооцон сар бүр;

2.1.2.энэ журмын 1.2.2-т заасан хугацааны тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын шимтгэлийг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн төлбөл зохих хувиар тооцон цэргийн анги, байгууллага сар бүр;

2.1.3.энэ журмын 1.2.3-т заасан хугацааны тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын шимтгэлийг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн төлбөл зохих хувиар тооцон сар бүр;

2.1.4.энэ журмын 1.2.4-т заасан хугацааны тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын шимтгэлийг шүүх, эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн даатгуулагчийн хууль бусаар ажлаас зайлуулагдан мөрдөгдөхийн болон хилс хэргээр хорих ял эдлэхийн өмнө авч байсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас ажил олгогчийн төлбөл зохих хувиар тооцон нэг удаа бүрэн хэмжээгээр;

2.1.5.энэ журмын 1.2.5-д заасан хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг шүүх, эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн даатгуулагчийн хууль бусаар ажлаас халагдахын өмнө авч байсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас ажил олгогчийн төлбөл зохих хувиар тооцон тухайн даатгуулагчийг ажилдаа эргэн орсноос хойш нэг сарын дотор нэг удаа бүрэн хэмжээгээр;

2.1.6.энэ журмын 1.2.7, 1.2.8, 1.2.10-т заасан хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн төлбөл зохих хувиар тооцон сар бүр;

2.1.7.энэ журмын 1.2.15-д заасан хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг төрийн албан хаагчийн үндсэн цалингийн дунджаас ажил олгогчийн төлбөл зохих хувиар тооцон сар бүр;

2.1.8.энэ журмын 1.2.17, 1.2.19-д заасан хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн төлбөл зохих хувиар тооцон сар бүр;

2.1.9.энэ журмын 1.2.18-д заасан хугацааны тэтгэврийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн төлбөл зохих хувиар тооцон сар бүр.

2.2.Төр шимтгэл төлснөөр тооцогдох дараах хугацааны шимтгэлийг тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын санд доор дурдсаны дагуу улсын төсвөөс төлнө:

2.2.1.энэ журмын 1.2.6-д заасан хугацааны шимтгэлийг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн төлбөл зохих хувиар тооцон сар бүр;

2.2.2.энэ журмын 1.2.9-д заасан хугацааны шимтгэлийг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс сайн дурын даатгуулагчийн төлбөл зохих хувиар тооцон сар бүр;

2.2.3.энэ журмын 1.2.12-т заасан хугацааны шимтгэлийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 3-т заасны дагуу төлөх бөгөөд эхийн төлбөл зохих шимтгэлийн 50 хувийг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс сайн дурын даатгуулагчийн төлбөл зохих хувиар тооцон сар бүр;

2.2.4.энэ журмын 1.2.14-т заасан хугацааны шимтгэлийг энэ хугацаанд тооцож байсан адилтгах албан тушаалын цалингаас ажил олгогчийн төлбөл зохих хувиар тооцон нэг удаа бүрэн хэмжээгээр;

2.2.5.энэ журмын 1.2.16-д заасан хугацааны шимтгэлийг алба хаагчийн авч байсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос ажил олгогчийн төлбөл зохих хувиар, өсгөн тооцох хугацааны шимтгэлийг шимтгэл төлөх үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн төлбөл зохих хувиар тооцон нэг удаа бүрэн хэмжээгээр.

2.3.Энэ журмын 1.2.11-д заасан хугацааны шимтгэлийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 2-т заасны дагуу төлөх бөгөөд тэтгэмж авах эрх үүссэн эхийн төлбөл зохих шимтгэлийн 50 хувийг тухайн үеийн сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс сайн дурын даатгуулагчийн төлбөл зохих хувиар тооцон тэтгэмжийн даатгалын сангаас сар бүр төлнө.



2.4.Энэ журмын 1.2.13-т заасан хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс албан журмын даатгуулагчийн төлбөл зохих хувиар тооцон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас сар бүр төлнө.

2.5.Энэ журмын 2.2.3, 2.3-т заасан эх өөрийн хариуцан төлөх шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2-т заасан хувь хэмжээгээр тооцож, гэрээнд заасан хугацаанд төлнө. Шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээш орлогоос төлөх тохиолдолд үүсэх зөрүүг даатгуулагч эх өөрөө хариуцан гэрээнд заасан хугацаанд төлнө.

2.6.Шимтгэл төлснөөр тооцогдох хугацааны шимтгэлийг энэ журмаар тогтоосон хугацаанд төлөөгүй тохиолдолд уг шимтгэлийг нөхөн төлөх үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, шимтгэлийн хувь хэмжээг баримтална.

Гурав.Шимтгэл төлснөөр тооцогдох хугацааны төлөгдсөн шимтгэлийг шилжүүлэх, бүртгэх, тайлагнах

3.1.Нийгмийн даатгалын төв байгууллага нь энэ журмын дагуу төлөгдсөн, мөн журмын 1.2.9, 1.2.11-1.2.14, 1.2.16-д тус тус заасан хугацааны шимтгэлийг холбогдох аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагын зохих сангийн дансанд шилжүүлэх бөгөөд тухайн аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь шимтгэл төлөлтийг нийгмийн даатгалын мэдээлэл бүхий мэдээллийн санд даатгуулагч бүрээр бүртгэнэ.

3.2.Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацааны шимтгэл төлөлтийн тайланг доор дурдсаны дагуу гаргана:

3.2.1.энэ журмын 1.2.1, 1.2.3-1.2.5, 1.2.7, 1.2.8, 1.2.10-т заасан хугацааны шимтгэл төлөлтийн тайланг ажил олгогч гарган нийгмийн даатгалын байгууллагад сар бүр;

3.2.2.энэ журмын 1.2.6-д заасан хугацааны шимтгэл төлөлтийн тайланг аймаг, сум, дүүргийн Засаг даргын тамгын газар гарган нийгмийн даатгалын байгууллагад сар бүр;

3.2.3.энэ журмын 1.2.9, 1.2.11, 1.2.12, 1.2.13-т заасан хугацааны шимтгэл төлөлтийн тайланг холбогдох аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага гарган нийгмийн даатгалын төв байгууллагад сар бүр;

3.2.4.энэ журмын 1.2.2-т заасан хугацааны шимтгэл төлөлтийн тайланг цэргийн анги, байгууллага гарган нийгмийн даатгалын байгууллагад сар бүр;

3.2.5.энэ журмын 1.2.15, 1.2.17-1.2.19-д заасан хугацааны шимтгэл төлөлтийн тайланг холбогдох байгууллагууд гарган нийгмийн даатгалын байгууллагад сар бүр.

3.3.Энэ журмын 1.2.14, 1.2.16-д заасан хугацааны шимтгэлийг тооцох, шилжүүлэх чиг үүргийг нийгмийн даатгалын байгууллага дараах байдлаар хэрэгжүүлнэ:

3.3.1.аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага нь дипломат төлөөлөгчийн газарт ажиллагчдын цаг уурын хүнд нөхцөл бүхий улсад ажилласан жилийн нэмэгдэл хугацаа, цэргийн байгууллагад алба хаасан жилийг энгийн жилд шилжүүлэн тооцсон тооцоолол, ажилласан хугацааны хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын тодорхойлолт, лавлагааны хамт нийгмийн даатгалын төв байгууллагад ирүүлнэ;

3.3.2.нийгмийн даатгалын төв байгууллага нь холбогдох баримтыг хянаж, тооцооллыг нэгтгэн нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад нэхэмжлэл хүргүүлнэ;

3.3.3.нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь нэхэмжлэлийг хянаж, нийгмийн даатгалын төв байгууллагын холбогдох дансанд шимтгэлийн мөнгийг тухай бүр шилжүүлнэ;

3.3.4.нийгмийн даатгалын төв байгууллага нь нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шилжүүлсэн шимтгэлийн мөнгийг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагын холбогдох сангийн харилцах дансанд шилжүүлнэ.

---o0o---



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 02 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 71

Улаанбаатар
хот

Үндэсний энгийн гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам шинэчлэн батлах тухай

Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Үндэсний энгийн гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт даалгасугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2016 оны 2 дугаар сарын 29-ний өдрийн 126 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Х.НЯМБААТАР

Засгийн газрын 2023 оны 02 дугаар
сарын 08-ны өдрийн 71 дүгээр
тогтоолын хавсралт

ҮНДЭСНИЙ ЭНГИЙН ГАДААД ПАСПОРТ ОЛГОХ, ЭЗЭМШИХ, ХАДГАЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Үндэсний энгийн гадаад паспорт (цаашид “гадаад паспорт” гэх)-ыг олгох, эзэмших, хадгалах болон түүнтэй холбогдсон бусад харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Гадаад паспортыг олгох, эзэмших, хадгалахтай холбогдсон үйл ажиллагаанд Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон энэ журмыг дагаж мөрдөнө.

1.3.“Үндэсний гадаад паспортын загвар, тодорхойлолт батлах тухай” Засгийн газрын 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 155 дугаар тогтоол хүчин төгөлдөр үйлчилж эхлэхээс өмнө буюу 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө олгосон гадаад паспорт хүчин төгөлдөр байна.

1.4.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ журамд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг баримтална.

1.5.Гадаад паспорт нь Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллага (ИКАО)-ын Док 9303 стандартыг хангасан дараах төрөлтэй байна:

1.5.1.цахим төхөөрөмжөөр уншигдах гадаад паспорт (MRTD);

1.5.2.иргэний биеийн давхцахгүй өгөгдөл (цээж зураг зэрэг)-ийн мэдээлэл бүхий чиптэй цахим гадаад паспорт (eMRTD).

1.6.Гадаад паспортад бичигдэх эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, бүртгэлийн дугаарын үсгийг хөрвүүлэхэд Стандартчиллын үндэсний зөвлөлөөс баталсан “Монгол кирилл үсгийн латин хөрвүүлэг” стандартыг баримтална.

1.7.Гадаад хэл дээр байгаа баримт бичгийн бичвэр энэ журмын 1.6-д заасан стандартаас зөрүүтэй бичигдсэн бол иргэний хүсэлт, нотлох баримтыг үндэслэн гадаад паспортад эцэг (эх)-ийн, эсхүл өөрийн нэрийн үсгийг хөрвүүлж бичиж болно.



1.8.Гадаад паспортын хүчинтэй хугацааг сунгахгүй.

1.9.Монгол Улсын иргэн (цаашид “иргэн” гэх) энэ журмын 1.5.1, 1.5.2-т заасан тус бүр нэг гадаад паспортыг Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 5.8-д заасан журмын дагуу зэрэг эзэмшиж болно.

Хоёр.Гадаад паспорт олгох

2.1.Иргэнд Улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, түүний орон нутаг дахь Улсын бүртгэлийн газар, хэлтэс, тасаг, (цаашид “улсын бүртгэлийн байгууллага” гэх) хилийн чанадад ажиллаж байгаа Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газар (цаашид “Дипломат төлөөлөгчийн газар” гэх) гадаад паспортыг олгоно.

2.2.Иргэн гадаад паспорт авах бол Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 17.6, 17.7-д заасны дагуу өөрийн биеэр бүртгүүлж, иргэн өөрөө, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч хүлээн авна.

2.3.Эрүүл мэндийн шалтгааны улмаас энэ журмын 2.2-т заасны дагуу өөрийн биеэр бүртгүүлэх боломжгүй тохиолдолд Иргэний хуулийн 62.3-т заасны дагуу итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан холбогдох нотлох баримтыг бүрдүүлэн мөн журмын 1.4.1-д заасан гадаад паспортын бүртгэлд бүртгүүлж болно.

2.4.Иргэнд Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 17.3-т заасны дагуу гадаад паспортыг 10 жилээр, 16-аас доош насны хүүхдэд 5 жилээр тус тус олгоно.

2.5.Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд тухайн иргэний мэдээлэл зөрүүтэй, зөрчилтэй тохиолдолд гадаад паспорт олгохгүй.

2.6.Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 17.9-д заасны дагуу гадаад паспорт, хил нэвтрэх үнэмлэх олгохыг түр түдгэлзүүлж болно.

2.7.Гадаад паспорт, хил нэвтрэх үнэмлэхийн бүртгэлийг түдгэлзүүлсэн хяналтын улсын байцаагчийн шийдвэрийг үндэслэн улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын иргэний улсын бүртгэлийн асуудал хариуцсан нэгж (цаашид “иргэний улсын бүртгэлийн асуудал хариуцсан нэгж” гэх) иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд холбогдох мэдээллийг хөтөлнө.

2.8.Энэ журмын 2.7-д заасан гадаад паспортын бүртгэл хөтлөхийг түдгэлзүүлсэн үндэслэл арилсны дараа иргэн гадаад паспорт авах хүсэлт гаргаж болно.

**Гурав.Гадаад паспорт эзэмших, хадгалах,
хүчингүй болгох**

3.1.Гадаад паспортыг тухайн иргэн өөрөө эзэмшиж, хадгална.

3.2.Иргэн гадаад паспорт эзэмшихдээ дараах үүрэг хүлээнэ:

3.2.1.гадаад паспортын бүртгэлд бүртгүүлэхдээ үнэн зөв мэдүүлэх;

3.2.2.гадаад паспортыг цэвэр гамтай, бүрэн бүтэн байдлыг ханган эзэмших, хадгалах;

3.2.3.гадаад паспортаа хаяж, үрэгдүүлсэн тохиолдолд улсын бүртгэлийн байгууллага, түүний орон нутаг дахь газар, хэлтэс, Дипломат төлөөлөгчийн газарт даруй мэдэгдэх;

3.2.4.гадаад паспорт хүлээж авахдаа түүнд бичигдсэн мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэд эсэх, гадаад паспортын бүрэн бүтэн байдлыг шалгах;

3.2.5.өөрийн гарын үсгийг гадаад паспортын холбогдох хэсэгт зурах;

3.2.6.зөрчилтэй, бусдын, хүчингүй болсон гадаад паспортыг ашиглахгүй байх.

3.3.Гадаад паспорт эзэмшигч холбогдох хууль тогтоомж болон энэ журмын 3.2-т заасныг зөрчсөнөөс үүсэх үр дагаврыг өөрөө хариуцна.

3.4.Эрх бүхий улсын бүртгэгч иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан дахь гадаад паспортын бүртгэлийг дараах тохиолдолд хүчингүй болгоно:

3.4.1.гадаад паспортын хүчинтэй хугацаа болон хуудас дууссан;

3.4.2.гадаад паспортыг хаясан, үрэгдүүлсэн, алдсан, гэмтээсэн бол хяналтын улсын байцаагчийн шийдвэрийг үндэслэн;

3.4.3.иргэний улсын бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулсан;

3.4.4.иргэн өөрийн дүр төрхийн өөрчлөлтийн шалтгаанаар хүсэлт гаргасан;

3.4.5.энэ журмын 9.3-т заасны дагуу шийдвэрлэснээс бусад тохиолдолд;

3.4.6. шүүхийн шийдвэрээр гадаад паспортын бүртгэлийг хүчингүйд тооцсон;

3.4.7. хяналтын улсын байцаагчийн шийдвэр гарсан;

3.4.8. хуульд заасан бусад.

3.5. Улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хулгайлагдсан, гээгдсэн болон хүчингүй болсон гадаад паспортын талаарх мэдээллийг Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллага (Интерпол)-д нэн даруй мэдэгдэж, “Хулгайлагдсан, гээсэн аяллын бичиг баримтын мэдээллийн сан”-д бүртгүүлнэ.

Дөрөв. Хил нэвтрэх үнэмлэх

4.1. Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газартай байгуулсан олон улсын гэрээнд дурдсан иргэнд хил нэвтрэх үнэмлэх олгоно.

4.2. Хил нэвтрэх үнэмлэхийг энэ журмын 4.1-д заасан гэрээ, Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 17.5, 17.6-д заасны дагуу хөтлөх бөгөөд олон улсын гэрээнд заасан аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс олгоно.

4.3. Иргэн хил нэвтрэх үнэмлэх авах бол Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 17.6 дахь хэсэгт зааснаас гадна дараах баримт бичгийг бүрдүүлж өөрийн биеэр хандана:

4.3.1. цээж зураг;

4.3.2. төлбөр төлсөн баримт.

4.4. Хил нэвтрэх үнэмлэхэд тухайн олон улсын гэрээнд заасан аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга гарын үсэг зурж, баталгаажуулна.

4.5. Иргэн хил нэвтрэх үнэмлэх эзэмшихдээ энэ журмын 3.2-т заасан үүрэг хүлээнэ.

4.6. Хил нэвтрэх үнэмлэх олгох үйл ажиллагаанд иргэний улсын бүртгэлийн асуудал хариуцсан нэгж хяналт тавина.

4.7. Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд хил нэвтрэх үнэмлэхийн бүртгэл хөтлөх, олгох, хяналт тавих ажлыг холбогдох улсын бүртгэлийн хэлтэс хариуцна.

Тав.Монгол Улсад буцах үнэмлэх

5.1.Гадаад паспортыг түр орлох баримт бичгийг Монгол Улсад буцах үнэмлэх (цаашид “буцах үнэмлэх” гэх) гэнэ. Буцах үнэмлэхийн загварыг Засгийн газар батална.

5.2.Буцах үнэмлэх хэвлүүлэх ажлыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохих журмын дагуу зохион байгуулна.

Зургаа.Буцах үнэмлэх олгох үндэслэл, түүний хүчинтэй байх хугацаа

6.1.Иргэнд дараах тохиолдолд буцах үнэмлэх олгоно:

6.1.1.гадаад паспортаа хаяж, үрэгдүүлсэн, гэмтээсэн;

6.1.2.гадаад паспортын хүчинтэй хугацаа дуусгавар болсон;

6.1.3.хүчин төгөлдөр буцах үнэмлэхээ хаяж, үрэгдүүлсэн, гэмтээсэн;

6.1.4.гадаадад төрсөн иргэн эх орондоо буцахад гадаад паспорт мэдүүлж авах боломжгүй;

6.1.5.Монгол Улсын олон улсын гэрээгээр шилжүүлэн авах иргэн гадаад паспортгүй;

6.1.6.ял эдлээд суллагдсан иргэн гадаад паспортгүй, эсхүл паспортын хүчинтэй хугацаа нь дуусгавар болсон;

6.1.7.сайн дураараа эх орондоо буцах хөтөлбөрт хамрагдах иргэн гадаад паспортгүй.

6.2.Буцах үнэмлэх мэдүүлэх шаардлагатай иргэний ургийн овог, эцэг/эхийн нэр, өөрийн нэрийг тодруулах, тухайн улсад бүртгэлтэй буюу оршин суух зөвшөөрөл дэх овог, нэрийн зөрчилтэй холбоотой асуудлыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Дипломат төлөөлөгчийн газар, улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хамтран шийдвэрлэх бөгөөд дараах лавлагаа, мэдээллийг солилцоно:

6.2.1.шаардлагатай тохиолдолд тухайн иргэний Монгол Улсын хилээр нэвтэрсэн лавлагаа;



6.2.2.энэ журмын 6.1.1, 6.1.2, 6.1.4-6.1.7-д заасан этгээд мэдүүлэх тохиолдолд тухайн иргэний талаар Монгол Улсын иргэний бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын лавлагаа.

6.3.Буцах үнэмлэхэд Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, консулын хэлтсийн дарга, тэдгээрийн эзгүйд орлох дипломат ажилтан гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулна.

6.4.Дипломат төлөөлөгчийн газар буцах үнэмлэх авах хүсэлтийг ажлын 7 өдрийн дотор шийдвэрлэнэ.

6.5.Буцах үнэмлэх нь олгосон өдрөөс 12 хүртэл сарын хугацаанд хүчинтэй байна.

Долоо.Буцах үнэмлэх мэдүүлэх

7.1.Буцах үнэмлэхийг энэ журмын 6.1-д заасан Монгол Улсын иргэн, шаардлагатай тохиолдолд түүнийг төлөөлөн дараах этгээд мэдүүлнэ:

7.1.1.Монгол Улсын олон улсын гэрээнд заасан эрх бүхий байгууллагын төлөөлөгч;

7.1.2.эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа иргэний хувьд тухайн эмнэлгийн захиргаа;

7.1.3.саатуулах байранд байгаа иргэний хувьд тухайн улсын цагдаагийн байгууллага, эсхүл шилжилт хөдөлгөөний асуудал хариуцсан байгууллага;

7.1.4.асрамжийн газарт байгаа насанд хүрээгүй хүүхдийн хувьд эцэг эх, асран хамгаалагч;

7.1.5.итгэмжлэгдсэн төлөөлөгч.

7.2.Буцах үнэмлэх мэдүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

7.2.1.буцах үнэмлэх мэдүүлэх хуудас;

7.2.2.иргэний үнэмлэхийн хуулбар, эсхүл иргэний улсын бүртгэлийн лавлагаа;

7.2.3.цээж зураг 2 хувь (3.5x4.5 см-ийн хэмжээтэй, цагаан дэвсгэртэй);



7.2.4.төлбөр төлсөн баримт;

7.2.5.энэ журмын 6.1.1, 6.1.3-т заасан этгээд мэдүүлэх тохиолдолд бичиг баримтыг хаяж, үрэгдүүлсэн тухай гадаад улсын эрх бүхий байгууллагын тодорхойлолт.

7.3.Энэ журмын 7.1-д заасан иргэн, эсхүл төлөөлж байгаа этгээд буцах үнэмлэх мэдүүлэх хуудаст гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

7.4.Буцах үнэмлэх мэдүүлэх баримт бичгийг Дипломат төлөөлөгчийн газар баталгаат шуудангаар хүлээн авч, баталгаат шуудангаар буцах үнэмлэхийг хүргүүлж болно.

7.5.Шаардлагатай тохиолдолд иргэнд буцах үнэмлэх олгох тухай гадаад улсын эрх бүхий байгууллагын хүсэлтийг консулын зөвлөлдөх уулзалтаар хэлэлцэж болно.

Найм.Буцах үнэмлэх олголтод тавих хяналт

8.1.Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буцах үнэмлэхийг Дипломат төлөөлөгчийн газруудад тараан олгож, зарцуулалтад хяналт тавина.

8.2.Дипломат төлөөлөгчийн газар нь буцах үнэмлэх олгосон баримтыг өөрийн байгууллагад 5 жил хадгалсны дараа устгана. Тухайн жилд олгосон буцах үнэмлэхийн тайланг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тасалбар болгон дараа оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор гарган хүргүүлнэ.

8.3.Дипломат төлөөлөгчийн газрын бүртгэлийн ажилтан (консулын ажилтан) буцах үнэмлэх олгосон талаар цахим мэдээллийн сан үүсгэж, хөтөлнө.

8.4.Буцах үнэмлэхийг хилийн шалган нэвтрүүлэх боомт дээр улсын хил хамгаалах байгууллага хураан авч гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Ес.Бусад

9.1.Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гадаад паспортын загвар, түүнд орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг Монгол Улсын болон гадаад улсын холбогдох байгууллагад нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.



9.2.Улсын бүртгэлийн байгууллага Дипломат төлөөлөгчийн газар гадаад паспорт, хил нэвтрэх үнэмлэхийн олголт, түүнтэй холбоотой тоон мэдээ, тайланг сар бүрийн 25-ны өдрийн байдлаар гаргаж, иргэний улсын бүртгэлийн асуудал хариуцсан нэгжид тухайн сарын 27-ны өдрийн дотор ирүүлнэ.

9.3.Энэ журмын 1.9-д заасан гадаад паспорт олгох асуудлыг холбогдох журмын дагуу улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага шийдвэрлэнэ.

9.4.Энэ журмын 1.7-д заасан хөрвүүлж бичих асуудлыг иргэний улсын бүртгэлийн асуудал хариуцсан нэгж шийдвэрлэнэ.

9.5.Гадаад паспортыг хэвлэх, олгох үйл ажиллагаанд улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгж жил бүр эрсдэлийн үнэлгээ хийнэ.

9.6.Гадаад паспорт авахаар хүсэлт гаргахдаа баримт бичиг хуурамчаар үйлдсэн, худал мэдээлэл өгсөн, гадаад паспортаа бусдад ашиглуулсан, худалдсан, барьцаалсан бол улсын бүртгэлийн байгууллага, холбогдох эрх бүхий байгууллагад шилжүүлж, шийдвэрлүүлнэ.

9.7.Улсын хил хамгаалах байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэх явцад зөрчилтэй, хүчин төгөлдөр бус гадаад паспорт, хил нэвтрэх үнэмлэхийг хураан авч, улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад шилжүүлнэ.

9.8.Улсын хил хамгаалах байгууллага чиг үүргийн хүрээнд гарсан гадаад паспорт, хил нэвтрэх үнэмлэхийн зөрчлийн мэдээллийг сар бүрийн 25-ны өдрийн байдлаар гаргаж, улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухайн сарын 27-ны өдрийн дотор ирүүлнэ.

9.10.Улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, түүний орон нутаг дахь газар, хэлтэс гадаад паспортын цахим мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

---оОо---



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 02 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 72

Улаанбаатар
хот

Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сангийн дүрэм, журам батлах тухай

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21³ дугаар зүйлийн 21^{3.6} дахь хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.2, 33.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сангийн дүрэм”-ийг 1 дүгээр хавсралт, “Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сангийн хөрөнгийг төвлөрүүлэх, бүрдүүлэх, зарцуулах журам”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.“Засгийн газрын үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 350 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Архидан согтуурахтай тэмцэх сангийн зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг 3 дугаар хавсралтаар өөрчлөн баталсугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Засгийн газрын үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 350 дугаар тогтоолын тэмдэглэх хэсгийн “Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 132.3” гэснийг “Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21³ дугаар зүйлийн 21^{3.6}” гэж, мөн тогтоолын 1 дэх заалтын “Архидан согтуурахтай тэмцэх сангийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг” гэснийг “Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сангийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг” гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Х.НЯМБААТАР

Засгийн газрын 2023 оны 02 дугаар
сарын 08-ны өдрийн 72 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ САНГИЙН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сан (цаашид “Сан” гэх)-ийн зорилго нь архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх цогц үйл ажиллагааг санхүүжүүлэхэд оршино.

1.2.Сан ашгийн төлөө бус байгууллага бөгөөд тогтоосон журмаар хийсэн тамга, тэмдэг, бэлгэдэл, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

1.3.Сан Төрийн санд харилцах данстай байна.

Хоёр.Сангийн удирдлага, зохион байгуулалт

2.1.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 33.2-т заасны дагуу Сан хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд ажиллана.

2.2.Сангийн үйл ажиллагааг удирдан зохицуулах, сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавих үүрэг бүхий 12 хүртэл хүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус удирдах зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) ажиллана.

2.3.Зөвлөлийн гишүүдийн зургаа нь төрийн байгууллагаас, зургаа нь олон нийтийн төлөөллөөс бүрдэх бөгөөд зөвлөлийн дарга нь хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.

2.4.Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд улиралд 1-ээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд Зөвлөлийн дарга Зөвлөлийн хуралдааныг зарлан хуралдуулж болно.

2.5.Зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонх оролцоноор хуралдааныг хүчинтэйд тооцож, оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

2.6.Зөвлөлийн хуралдааны явцын тухай тэмдэглэл хөтөлж, дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.



2.7.Зөвлөлийн дарга Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сангийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилт, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавина.

2.8.Зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.8.1.Сангийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

2.8.2.Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жилийн төлөвлөгөө, төсөв, урсгал зардлыг батлах;

2.8.3.Сангийн үйл ажиллагааны тайлан, архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны арга хэмжээний үр дүнгийн талаарх мэдээлэл, судалгааг холбогдох мэргэжлийн байгууллагаас гаргуулан авах;

2.8.4.Сангийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа төсөл, арга хэмжээний явцад хяналт тавих, тайланг хэлэлцэх.

2.9.Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга байх бөгөөд дараах эрх, үүрэгтэй байна:

2.9.1.Зөвлөлийн хуралдааны төлөвлөгөөг гаргаж, Зөвлөлийн даргаар батлуулан хурлыг зохион байгуулах;

2.9.2.Зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийг албажуулах;

2.9.3.Зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж, Зөвлөлийн хуралдаанд танилцуулах.

2.10.Сангийн ажлын албаны чиг үүргийг Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга хариуцах бөгөөд дараах эрх, үүрэгтэй байна:

2.10.1.Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

2.10.2.Сангийн үйл ажиллагааны талаар хууль тогтоомжид нийцүүлэн тушаал, заавар гаргах;

2.10.3.холбогдох хууль тогтоомж, төсөл, арга хэмжээний жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих;



2.10.4.Сангийн санхүүгийн төлөвлөгөө, төсвийн төслийг салбарын бодлого, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлийн зорилтуудтай уялдуулан боловсруулж, Сангийн Зөвлөлд хүргүүлэх;

2.10.5.Сангаас санхүүжүүлж байгаа төсөл, арга хэмжээний явцыг шалгаж, үр дүнг тооцох, түүнтэй холбогдсон мэдээ, тайлан гаргуулж авах, шаардлагатай гэж үзвэл санхүүжилтийг зогсоох саналыг Зөвлөлд танилцуулж, шийдвэрлүүлэх;

2.10.6.Сангийн хөрөнгийн зарцуулалтын явц, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнгийн талаар Зөвлөлд улирал тутамд тайлагнаж байх;

2.10.7.Зөвлөлийн гаргасан шийдвэрийн дагуу Санг төлөөлөн гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;

2.10.8.Зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд Санг төлөөлөх;

2.10.9.улсын төсвөөс Санд олгох хөрөнгийн хэмжээг өмнөх онд олгосон хөрөнгийн хэмжээ, ирэх онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний шаардагдах зардал, сангийн дотоод үйл ажиллагааны зардал зэргийг тооцон төлөвлөх.

Гурав.Сангийн хяналтын хороо, түүний үйл ажиллагаа

3.1.Сан Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 25.5-д заасны дагуу Сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд хяналт тавих хяналтын хороотой байна.

3.2.Сангийн хяналтын хороо нь 3 гишүүнтэй байх бөгөөд холбогдох төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллага болон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тус бүр 1 төлөөлөлтэй байна.

3.3.Сангийн хяналтын хороо улиралд нэгээс доошгүй удаа хуралдаж Зөвлөлд ажлаа тайлагнана.

Дөрөв.Бусад

4.1.Сангийн хөрөнгийг бусдад хандивлах, барьцаалах, зориулалт бусаар зарцуулах, зээлээр ашиглах, ашиглуулах аливаа үйлдлийг хориглоно.

4.2.Энэ дүрмийг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хуулийн хариуцлага хүлээлгэнэ.

----oO----

Засгийн газрын 2023 оны 02 дугаар
сарын 08-ны өдрийн 72 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

**АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ
АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ САНГИЙН ХӨРӨНГИЙГ ТӨВЛӨРҮҮЛЭХ,
БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.3.25-д заасан Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сан (цаашид “Сан” гэх)-ийн хөрөнгийг төвлөрүүлэх, бүрдүүлэх, зарцуулахтай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 22.5-д заасны дагуу хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хариуцан удирдаж, мөн хуульд заасан журмын дагуу хяналт тавьж, тайлагнана.

1.3.Онцгой албан татварын тухай хуулийн 6.1¹-д заасны дагуу ногдуулан хураасан онцгой албан татварын орлогын гүйцэтгэлээс татвар ногдсон согтууруулах ундааны литр тутам хамаарах 300 төгрөгийн орлогыг Санд төвлөрүүлэхтэй холбогдох харилцааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21³.4-т заасан журмаар зохицуулна.

Хоёр.Сангийн хөрөнгийг төвлөрүүлэх, бүрдүүлэх

2.1.Сангийн хөрөнгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 22.1-д заасны дагуу Төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулна.

2.2.Сангийн хөрөнгө нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, 21³.3-т заасан дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

2.2.1.улсын төсвийн хөрөнгө;

2.2.2.хандив, тусламж;

2.2.3.Онцгой албан татварын тухай хуулийн 6.1¹-д заасны дагуу ногдуулан хураасан татварын орлогын гүйцэтгэлээс татвар ногдсон согтууруулах ундааны литр тутам хамаарах 300 төгрөгийн орлого.



Гурав.Сангийн хөрөнгийг зарцуулах

3.1.Сангийн хөрөнгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21³ дугаар зүйлийн 21³.2-т заасан дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

3.1.1.архидан согтуурахтай тэмцэх, түүний хор уршгийг олон нийтэд хүртээмжтэй таниулан сурталчлах;

3.1.2.согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтын зардлын төлбөрийн 50 хувийг;

3.1.3.согтуурах, мансуурах дон болон дэлгэцэд донтох өвчний хор уршигтай тэмцэхэд чиглэсэн зайлшгүй шаардлагатай тусламж, үйлчилгээг хүн амд хүргэх;

3.1.4.согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний барилга байгууламж, тоног төхөөрөмж бусад тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;

3.1.5.архидан согтуурахтай тэмцэх, согтууруулах ундааны хор уршиг, хэрэглээний эсрэг бусад үйл ажиллагааг.

3.2.Энэ журмын 3.1-д заасан арга хэмжээг санхүүжүүлэх шийдвэрийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргаж, дараах хэлбэрээр олгоно:

3.2.1.урьдчилгаа олгож гүйцэтгэлээр санхүүжүүлэх буюу тухайн ажил, үйлчилгээний онцлог, шаардагдах хөрөнгийн хэмжээтэй ялдуулан үе шаттайгаар санхүүжүүлэх;

3.2.2.шууд санхүүжүүлэх буюу ажил, үйлчилгээг гүйцэтгэсний дараа санхүүжилтийг бүрэн хэмжээгээр нэг удаа олгох.

Дөрөв.Сангийн хөрөнгийн зарцуулалтыг тайлагнах, хянах

4.1.Сангийн тайлан, хөрөнгийн зарцуулалтад Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн Тавдугаар бүлэгт заасны дагуу хяналт тавьж, тайлагнана.

4.2.Сангийн зарцуулалтын жилийн эцсийн тайланд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аудит хийж, дүгнэлтийн хамт уг тайлан гарснаас хойш 20 хоногийн дотор байгууллагын цахим хуудас болон шилэн дансанд байршуулна.



4.3. Сангийн орлого, зарлагын тайланг харьяалах татварын албанд тайлагнана.

4.4. Сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжилт авсан төсөл, арга хэмжээний мэдээллийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 24.2-т заасны дагуу олон нийтэд мэдээлж, тогтмол шинэчилнэ.

Тав.Бусад

5.1. Сангийн хөрөнгийг бусдад хандивлах, барьцаалах, зориулалтын бусаар зарцуулах, зээлээр ашиглах, ашиглуулах аливаа үйл ажиллагааг хориглоно.

5.2. Энэ журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

5.3. Сангийн эх үүсвэрээр төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх шийдвэр гаргах албан тушаалтан нь холбогдох хуульд заасан журмын дагуу ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлнэ.

----oOo----



Засгийн газрын 2023 оны 02 дугаар
сарын 08-ны өдрийн 72 дугаар
тогтоолын 3 дугаар хавсралт

Засгийн газрын 2022 оны 9 дүгээр
сарын 22-ны өдрийн 350 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

**АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ
АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ САНГИЙН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Удирдах зөвлөлийн
дарга:

-Хууль зүй, дотоод хэргийн сайд

Гишүүд:

-Хууль зүй, дотоод хэргийн яамны
Санхүү, хөрөнгө оруулалтын газрын
дарга;

-Сангийн яамны Татварын бодлогын
газрын дарга;

-Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн
тусламж, үйлчилгээний газрын дарга;

-Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга
бөгөөд Нийслэлийн цагдаагийн
Удирдах газрын дарга;

-олон нийтийн төлөөлөл (Монголын
хүнсчдийн холбоо);

-олон нийтийн төлөөлөл (Монголын
хүнсчдийн холбоо);

-олон нийтийн төлөөлөл (Монголын
хүнсчдийн холбоо);

-олон нийтийн төлөөлөл (Монголын
хүнсчдийн холбоо);

-олон нийтийн төлөөлөл (Монголын
үндэсний худалдаа, аж үйлдвэрийн
танхим);



Нарийн бичгийн
дарга:

-олон нийтийн төлөөлөл (Европ,
Монголын хамтарсан худалдаа, аж
үйлдвэрийн танхим);

-Хууль зүй, дотоод хэргийн яамны
Бодлогын хэрэгжилтийг зохицуулах
газрын дарга.

----o0o----

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 5

Индекс: 200003